




Хадгаламжийн сертификат гэж юу вэ?



Хадгаламжийн сертификат (ХС) нь ердийн хадгаламжаас илүү өндөр хүү санал болгодог тодорхой хугацаатай нэрлэсэн үнэ бүхий хадгаламжаар баталгаажсан үнэт цаас юм.

Хадгаламжийн сертификат ямар онцлогтой вэ?



Тодорхой хугацаатай:

Богино хугацаат – 3 сар, 6 сар, 1 жил
Урт хугацаат – 2 жил, 5 жил



Илүү өндөр хүүтэй:

Бусад хадгаламжийн бүтээгдэхүүнээс илүү өндөр хүүтэй байдаг.



Баталгаатай :

Банк болон төрийн хадгаламжийн даатгалын байгууллагаар (зарим төрлийг) баталгаажуулдаг.



Хатуу нөхцөлтэй:

Хадгаламжийн хугацааны дундуур цуцлах болон хугацаа дуусахад сунгах боломжгүй.



Төрлөөс хамааран хадгалуулсан хөрөнгө үнэт цаасаар баталгаажиж байгаа тул бусдад худалдах, бэлэглэх, өвлүүлэх, барьцаалах боломжтой.

Уламжлалт хадгаламжийн сертификат

банкаас гаргадаг,
тодорхой хугацаа,
хүүгийн нөхцөлтэй
хадгаламжийн
гэрчилгээ юм.



Хадгаламжийн
сертификатын үндсэн
төрөл

Арилждаг хадгаламжийн сертификат

хоёрдогч зах зээл дээр
худалдаалах,
шилжүүлэх боломжтой
үнэт цаасны төрөл юм.

Уламжлалт хадгаламжийн сертификат



Эзэмшигч нь зөвхөн
гаргасан банкаас мөнгөө
буцааж авна;



Хөрвөх чадвар бага;



Тогтмол хүүтэй;



Эрсдэл багатай.



Зах зээл дээр худалдаж,
бусдад шилжүүлэх
боломжтой;



Хөрвөх чадвар өндөр.
Арилжааны зах зээл дээр
худалдаалагддаг;



Ихэвчлэн өндөр хүүтэй, зах
зээлийн нөхцлөөс хамаарч
өөрчлөгдөж болно;



Эрсдэл арай өндөр. Зах
зээлийн үнээс хамаарч
үнэгүйдэх боломжтой.

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-д хадгаламжийн
сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжих боломжийг тусгасан.

